



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 363

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын (Увс аймаг Улаангом сум) хүрээнд бий болсон, нийт 2,638,592,248.00 (хоёр тэрбум зургаан зуун гучин найман сая таван зуун ерэн хоёр мянга хоёр зуун дөчин найм) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Увс аймаг дахь Гаалийн газрын хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээн авч, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
368 дугаар тогтоолын хавсралт

УВС АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Хяналт, бүрдүүлэлтийн барилга /2 давхар, зоорьтой/	2024	м2	864	2,332,512.94	2,015,291,184.00
2	Явган зам /м2/	2024	м2	375	35,271.97	13,226,989.00
3	Авто зогсоол /м2/	2024	м2	307	199,328.81	61,193,946.00
4	Гадна хашаа /м2/	2024	м2	124.12	505,242.85	62,710,742.00
5	Ногоон байгууламж /м2/	2024	м2	102	151,951.13	15,499,015.00
6	Гадна дулааны шугам /метр/	2024	м	102	2,822,859.60	287,931,679.00
7	Холигч насосны узель /ширхэг/	2024	ш	1	37,121,341.00	37,121,341.00
8	Гадна бохир усны шугам /метр/	2024	м	98.5	341,267.48	33,614,847.00
9	Гадна цахилгаан /метр/	2024	м	165	69,629.84	11,488,924.00
10	Гадна холбооны шугам /метр/	2024	м	287	152,051.44	43,638,763.00
11	Гадна гэрэл /том/ ширхэг	2024	ш	10	3,334,486.00	33,344,860.00
12	Гадна гэрэл /жижиг/ ширхэг	2024	ш	6	1,754,993.00	10,529,958.00
13	Зураг төсвийн үнэ				13,000,000.00	13,000,000.00
Нийт дүн						2,638,592,248.00
						(хоёр тэрбум зургаан зуун гучин найман сая таван зуун ерэн хоёр мянга хоёр зуун дөчин найм)